



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 25/33

Улаанбаатар хот

┌ Удирдах зөвлөл, Төлөөлөн удирдах ┐
Зөвлөлийн гишүүд болон хараат бус
гишүүдийг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 35 дугаар зүйлийн 35.1.11, 35.1.12 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Удирдах зөвлөл, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон хараат бус гишүүдийг томилж, нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Компанийн тухай хууль, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан "Удирдах зөвлөлийн ажиллах журам", "Нийслэлийн өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдэд төлөөлөл хэрэгжүүлэх журам" болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөн ажиллахыг томилогдсон гишүүдэд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн хороо (Б.Сэмжидмаа)-нд даалгасугай.

ДАРГА



А.БАЯР